



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 411

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам" шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д дор дурдсан агуулгатай 4.8¹. дахь хэсэг нэмсүгэй:

1/ Журмын 4.8¹. дахь хэсэг:

"Хорооноос тогтоосон журмын дагуу итгэлцэл, хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь уг тусгай зөвшөөрлийн хүрээнд энэхүү журмын 4.7-д заасан хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хавсран эрхэлж болно."

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д холбогдох өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-д тус тус даалгасугай.

ДАРГА



ЗНАРАНТУЯА

001083